

ШҮҮХИЙН БУС ЖУРМААР ӨР БАРАГДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 32 дугаар тогтоолын 3-т “санхүүгийн гэрээ, хэлцэлд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, тэдгээрийн хооронд үүссэн маргааныг шүүхээс богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх, барьцаалагчийн шаардах эрхийг хангуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагчийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах” гэж, мөн оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолын хавсралтын 3.1.8-д Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийж, санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэхээр заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын хавсралтын 73-т “Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх” гэж, мөн оны 75 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэх асуудал”-д Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөл гэж тус тус тусгажээ.

Ийнхүү дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хийсэн урьдчилан тандан судалгаанд тусгагдсан хэрэгцээ, шаардлагад үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах зохицуулалт тусгалаа.

Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг шүүхийн журмаар хангуулахад гардаг хүндрэл, бэрхшээлийг багасгах, бизнес эрхлэгчдийн зардал, цаг хугацааг хэмнэх боломж бүрдүүлэх үүднээс шүүхийн бус журмаар өр барагдуулах арга замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах сонголтыг бий болгож, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор уг хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд зээлдэгч болон зээлдүүлэгч нарын хооронд өрийн тохиролцоо хийх шинэлэг зохицуулалтыг тусгаж, тийнхүү өрийн тохиролцоо хийх, өр барагдуулах үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн өр барагдуулах алба эрхлэхээр заасан болно.

Өр төлбөр барагдуулах явцад зээлдэгчийн хууль ёсны эрхэд хууль бусаар халдах явдал гарсаар байгаа тул өр барагдуулах алба болон түүний ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлж, зээлдүүлэгчтэй зүй зохистой харилцах, хууль ёсны эрхэд халдахгүй байх нөхцөлийг бүрдүүллээ.

Тухайлбал Эрүүгийн хуулийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, эдийн засгийн гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хариуцлага хүлээж байсан, согтууруулах болон мансууруулах бодисоос хамааралтай этгээд нь өр барагдуулах албаны эрх бүхий албан тушаалтан, ажилтнаар ажиллахыг хориглосон болно.

Түүнчлэн өр барагдуулах албаны зүгээс өр төлбөртэй этгээдтэй харилцах хугацааг ажлын өдөр 8-21 цагт хооронд, биечлэн харилцах хугацааг долоо хоногт 3-аас дээшгүй байхаар хязгаарласнаас гадна нэр хүндэд нь халдах, албадах, сүрдүүлэх, дарамтлах байдлаар өр төлбөртэй этгээдтэй харилцахыг хориглож, хэрэв хориглосон үйлдэл гаргасан тохиолдолд Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээхээр хуулийн төсөлд тусгалаа.

Мөн зээлийн гэрээний талуудын бизнесийн болон хувь хүний нууцыг хамгаалах зорилгоор зээлийн гэрээ, түүний нөхцөл, гэрээний талуудын мэдээлэл зэрэг өр барагдуулах үйл ажиллагааны явцад цуглуулсан баримт, мэдээллийг өр барагдуулах үйл ажиллагааны нууцад хамааруулав.

Харин зээлийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдийн дотоод бүтцийн өр барагдуулах чиг үүрэг бүхий нэгж, хөдөлмөрийн болон бусад гэрээний үндсэн дээр хууль зүйн мэргэжлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлж буй этгээдийн өр төлбөр барагдуулах төрлийн үйл ажиллагаанд энэ хууль үйлчлэхгүй байх зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн зээлдүүлэгч өр барагдуулах үйл ажиллагааны үед шүүхэд нэхэмжлэл гаргаснаар өр барагдуулах үйл ажиллагааг зогсоохоор зааж, зээлдэгчийн шүүхэд гомдол гаргах үндсэн эрхийг хангасан зохицуулалтыг тусгалаа. Өөрөөр хэлбэл зээлдүүлэгч зээлийн гэрээний маргааныг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх, шүүхэд хандах үндсэн эрхээ эдлэхээс гадна өрийн тохиролцоог дахин уян хатнаар хийж үүргийг үр дүнтэй хангуулах зорилгоор шүүхийн бус журмаар өр барагдуулах ажиллагааг сонгох боломжийг бүрдүүлэхээр хуулийн төслийн боловсрууллаа.

Ингэснээр иргэд, бизнес эрхлэгчдийн зардал, цаг хугацааг хэмнэх, шүүхийн ачаалал буурах, санхүүгийн зах зээлийн хувьд мөнгөний эргэлт удаан хугацаанд түгжигдэхгүй байх, зээлийн хүү буурахад эерэг нөлөө үзүүлнэ гэж үзлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай зэрэг хуулийн төслийг дагалдуулан боловсрууллаа.

----oOo----